

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “ДАРХАН ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ДАА-2020/06/-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат
Утас: 70373089 Цахим хаяг: chultembatch@audit.gov.mn
Аудитын менежер Ш.Мөнхбаяр
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор Ш.Ганчимэг
Утас: 70378845 Цахим хаяг: ganchimegsh@audit.gov.mn
Аудитор Г.Батмягмар
Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Дархан-Уул аймаг


2020 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАЖ БАЙНА.	7
1.1. Дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж ажилласан байна	7
1.1.1. Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй байна.	7
1.1.2. Тус компани зорилтот түвшинг 2018 онд 100 хувь, 2019 онд 98.6 хувиар биелүүлж, төлөвлөгдсөн алдагдлыг бууруулж ажиллажээ.	8
1.1.3. Ажлын дадлага туршлагатай боловсон хүчин бүрдсэн байна.	10
1.2. Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.	11
1.2.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулаагүй байна.	11
1.2.2. Ажлын баримт материалын архивын нэгж болгох, баримтжуулах ажил хангалтгүй байна.	11
БҮЛЭГ 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН БИЕЛЭЛТ КОМПАНИЙН АШИГТ ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛЖЭЭ.	13
2.1. Компанийн ТУЗ 2018 оны борлуулалтын орлогыг 379.8 сая, 2019 онд 193.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баталсан байна.	13
2.1.1. Дулаан хэрэглэгчийн талбайн ашиглалтад тавих хяналт сулаас орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн тооцож, төлөвлөөгүй байна.	13
2.1.2. Үйл ажиллагааны бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж төлөвлөсөн байна.	13
2.1.3. Үйл ажиллагааны бус орлогын 56.6-62.0 хувийг тендерийн болон гэрээгээр гүйцэтгэсэн ажлын орлого эзэлж байгаа бөгөөд энэ нь алдагдлыг бууруулахад нөлөөлж байгаа ч цаашид тендерийн ажилд анхаарлаа хэт хандуулж байгаа нь нөгөө талаас компанийн үндсэн үйл ажиллагаанд гарах эрсдэлийг тооцож үзэх хэрэгтэй юм.	14
2.2. Үйл ажиллагааны зардал 2019 онд 217.3 сая төгрөгөөр хэтэрчээ.	15
2.2.1. Үйл ажиллагааны бус зардал нь гэрээт ажлууд нэмэгдэж хийсэнтэй холбоотойгоор хэтэрч байна.	15
2.2.2. 2019 онд ажилтны үндсэн болон тариф цалинг 8 хувиар нэмэгдүүлжээ.	16
2.2.3. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 2018, 2019 онд нийт 754.1 сая төгрөгийг зарцуулжээ.	17
БҮЛЭГ 3. ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ СУЛ БАЙНА.	20
3.1. Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө 100 хувь биелжээ.	20
3.1.1. Худалдан авах бараа, ажил үйлчилгээ өмнөх онуудаас нэмэгдэж байна.	20
3.1.2. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.	20
3.1.3. Худалдан авах үйл ажиллагаа 100 хувь хэрэгжсэн байна.	22
3.2.1. Хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө хадгалагдаж байна.	22
3.2.2. Өмч хамгаалах зөвлөл журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	23
Саналд өгсөн тайлбар:	24
ДҮГНЭЛТ:	25
ЗӨВЛӨМЖ:	26
ХАВСРАЛТУУД:	27

Товчилсон үгийн тайлбар

ДДС	Дархан Дулааны Сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ДЭХ	Дулааны эрчим хүч
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ДДЦС	Дархан Дулааны Цахилгаан Станц
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
ГАУС	Галын аюулаас урьдчилан сэргийлэх
ХОС	Хувийн орон сууц
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ОУБ	Олон улсын байгууллага
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУ	Монгол Улс
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТОӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ДХТ	Дулаан хуваарилах төв



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2019 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт	8
Хүснэгт 2	Нийт авлагын үлдэгдлийн ангилал	9
Хүснэгт 3	ДЭХ-ний авлагын үлдэгдлийг харуулбал:	9
Хүснэгт 4	Ажиллагсдын мэргэшил, мэргэжлийн зэргийн судалгаа	10
Хүснэгт 5	Үйл ажиллагааны бус орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсан хүснэгт	13
Хүснэгт 6	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл харьцуулсан судалгаа	16
Хүснэгт 7	Нийгмийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	18
Хүснэгт 8	2018, 2019 оны бараа, ажил үйлчилгээний зардлын төсөв	20

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		




Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ажилласан жилийн судалгаа	10
Дүрслэл 2	Насны ангилал	10

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Шинээр мөрдөж эхэлсэн үнэ тарифын судалгаа	27
Хавсралт 2	2018-2019 оны “ДДС” ТӨХК-ийн орон тооны харьцуулсан судалгаа	29
Хавсралт 3	Цалингийн зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулсан судалгаа	29



	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагаа, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль / <i>шинэчилсэн найруулга</i> -ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилт	<p>“ДДС ТӨХК-ийн 2018, 2019 оны үйл ажиллагаа, үр дүн”-д аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➢ <i>Тус компанийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;</i>➢ <i>Компанийн үйл ажиллагааны орлогыг зүй зохистой зарцуулж байгаа эсэх;</i>➢ <i>Худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байгаа эсэх;</i>
	Аудитыг “ДДС” ТӨХК-ийн 2018, 2019 оны үйл ажиллагааны зорилтот түвшин, түүний биелэлт, орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 100 хувь хамруулан, нийт зардлаас цалин, удирдлагын болон их засвар, худалдан авах үйл ажиллагаа, нийгмийн зардлыг хамруулан гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, нотлох зүйлсийг цуглуулан нягтлан шалгах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг ажлыг гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	<p>Аудитыг Дархан-Уул аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэлтсийн дарга, аудитын менежер Ш.Мөнхбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Ганчимэг, аудитор Г.Батмягмар нар хамтран төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитын төлөвлөгөөг 2020 оны 09 дүгээр сарын 07-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 10 дугаар сарын 20 хүртэл гүйцэтгэж, тайланг 2020 оны 10 дугаар сарын 30-нд тэргүүлэх аудитораар баталгаажуулж хүргүүлэв.</p>
Хүндрэл бэрхшээл

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАЖ БАЙНА.

1.1. Дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж ажилласан байна.

1.1.1. Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй байна.

“Дарханы Дулааны сүлжээ” ТӨХК үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй, гүйцэтгэх захирлын “А-13 дугаар тушаалаар дараах бодлогын баримт бичгүүдийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн байна. Үүнд:

“Техникийн бодлогын баримт бичиг” 2017-2030 он.

Бодлогын баримт бичгийг боловсруулахдаа дулааны ачааллын, дамжуулах болон түгээх шугам хоолойн гэмтлийн, сүлжээний насжилт, ашиглалтын зэрэг судалгааг үндэслэн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэн 2030 онд хүрэх үр дүнг тодорхойлжээ. Уг бодлогын баримт бичигт шугам хоолойн өргөтгөл шинэчлэлт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгийн нөөц, эх үүсвэрийг тусгажээ.

“Хүний нөөцийн бодлогын баримт бичиг” 2017-2025 он.

Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай ажилтныг сонгон шалгаруулах замаар хүний нөөцийг бүрдүүлэх, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын удирдлагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор уг бодлогын баримт бичгийг боловсруулжээ. Мэдээллийн технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, үүний үр дүнд орон тоог хэмнэх, одоо байгаа түвшинд барих талаар тусгаагүй байгаа нь компанийн эрхэм зорилгын алдагдлыг бууруулах гэсэн зорилттой нийцээгүй байна. Харин бодлогын баримт бичиг боловсруулах явцад хийсэн судалгаагаар зайлшгүй хэрэгцээтэй буюу шаардлагагүй орон тоог гаргаж ирсэн үр өгөөжтэй болжээ. Бодлогын баримт бичгийг үндэслэн хүний нөөцийн 2017-2025 он хүртэл хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулжээ.

“Санхүүгийн удирдлагын бодлогын баримт бичиг”

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээс тусдаа боловсруулагдсан, компанийн санхүүгийн нөөц, үндсэн үйл ажиллагаа, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт, их засварын ажлын санхүүжилтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бүтээмж, ашгийг нэмэгдүүлэх зорилготой боловсруулагдсан байна.

“Эрчим хүч хэмнэлтийн бодлогын баримт бичиг” 2017-2022

Энэ баримт бичигт дулаан дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулах, шинэ технологи нэвтрүүлэх, эрчим хүч хэмнэх бодлогоо 2017-2022 он хүртэл 3 үе шаттайгаар төлөвлөн, хэрэгжүүлэхээр тусгажээ. Дулаан түгээлт, шугамын алдагдал болон цахилгаан эрчим хүч хэмнэх талаар судалгааны ажил хийж, үр ашгийг тооцон цаашид баримтлах бодлогыг хэрэгжүүлэхээр ТУЗ-д танилцуулж, батлуулсан нь үр дүнтэй болжээ.

Бодлогын баримт бичгүүдээс зөвхөн техникийн бодлогын баримт бичгийн эхний үе шатны хэрэгжилтийг дүгнэсэн бөгөөд биелэлт 72 хувьтай гарсан байв.

Чухал хэрэгцээтэй бодлогын баримт бичгүүдийг боловсруулсан ч цаашид компанийн үйл ажиллагаанд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна.

1.1.2. Тус компани зорилтот түвшинг 2018 онд 100 хувь, 2019 онд 98.6 хувиар биелүүлж, төлөвлөгдсөн алдагдлыг бууруулж ажиллажээ.

2018 онд “ДДЦС” ТӨХК-аас 519.5 мян.Гкал ДЭХ худалдан авч түгээн борлуулж, 8,542.4 сая төгрөгийн борлуулалтын орлого, 508.1 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлого тус тус олж, 9,171.6 сая төгрөгийн зардал гарган татварын дараах дүнгээр 125.4 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 120.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

“ДДС” ТӨХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 679 дугаар тогтоолоор, 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг Эрчим хүчний Сайдын 2019 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тушаалаар тус тус баталжээ.

Компанийн ТУЗ 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд ДЭХ-ийн түгээлтийг 4.50 мян.Гкал-р, нийт орлогыг 627.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, цэвэр ашгийг 678.7 сая төгрөгөөр бууруулан, алдагдлыг 245.7 сая төгрөгөөр баталжээ. 2019 оны зорилтод түвшинг батлахдаа 532.63 мянган Гкал дулааны эрчим хүч түгээхээр, нийт орлогыг 9,443.6 сая, нийт зардлыг 9,773.9 сая төгрөгөөр төлөвлөжээ. Харин 330.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан нь өмнөх оныхоос 85.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Эрчим хүчний яам 2019 оны зорилтот түвшин, үйл ажиллагааны зардлаас жилийн үр дүнгийн шагнал 64.1 сая төгрөг хасаж бусад зорилтуудыг хэвээр баталжээ.

Хүснэгт №1

2019 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Зорилтын хувь	
1	Түгээсэн дулаан	Уураар	мян.Гкал	5.60	10.85	5.25	193.7
		Усаар	мян.Гкал	527.03	527.3	0.0	100,0
2	ДЭХ-ний алдагдал	хувь	хувь	13.30	13.23	-0.07	99.5
		биетээр	мян.Гкал	70.09	69.75	-0.34	99.5
3	Борлуулах ДЭХ	Уураар	мян.Гкал	5.60	10.85	5.25	193.7
		Усаар	мян.Гкал	456.93	457.28	0.34	100.1
4	Нийт орлого		сая.төг	9,443.05	10,289.19	846.15	109.0
			сая. төг	9,080.95	9,551.73	470.78	105.2
5	Нийт зардал		сая.төг	9,773.95	9,991.20	217.25	102,2
6	Татварын өмнөх ашиг, ал			-330.91	297.99	-32,92	190.05
				-330.91	249.00		
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.035	0.971	-0.064	93.82
8	Нийт авлага		сая.төг	974.11	1,480.92	506.81	152.02
9	Нийт өр төлбөр		сая.төг	1,416.87	1,893.16	476.29	48.0

10	ТЗБАХ, хөрөнгө оруулалт, их засвар	сая.төг	1,429.50	1,361.34	-68.16	100.0
11	Аваарь саатал	сая.төг	-	-	-	-
12	БО-ны шинэчлэл, иновацийн асуудлыг шийдсэн байдал	сая.төг	28.61	25.60	-3.01	89.47
13	Борлуулалтын авлага цуг	хувь	100.00	98.70	-1.3	98.7
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	189	184	-5	100.0
12	Нийт цалингийн сан	сая.төг	3,074.49	3,089.7	15.21	100.0
13	Нэг ажилтны дундаж цалин	сая.төг	1.4	1.4	0.0	100.0
	Дундаж хувь хэмжээ		100.0	98.7		

2019 онд “ДДЦС” ТӨХК-аас нийт 537.87 мян.Гкал ДЭХ-ийг худалдан авч Дархан сумын 13791 айл өрх, 1646 ААН-д түгээж нийт 10,289.16 сая төгрөгийн орлого олж, 249.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Энэ нь батлагдсан алдагдлыг 579.9 сая төгрөгөөр буюу 1.8 дахин бууруулсан. Үүнд 6 дугаар сарын 1-ээс айл өрхийн ДЭХ-ний тарифын өөрчлөлт, үйл ажиллагааны бус орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт №2

Нийт авлагын үлдэгдлийн ангилал

Үзүүлэлт	2019.01.01	2019.12.31	Өөрчлөлт	
			тоо	хувь
Үйлдвэрлэлийн байгууллага	105.56	167.43	61.87	58.60%
Худалдаа үйлчилгээний байгууллага	247.91	340.83	92.92	37.80%
Төсвийн байгууллага	1.65	0	-1.65	-100%
Оршин суугч, ахуйн хэрэглэгчид	441.36	510.27	68.91	5.60%
Бусад авлага	18.97	462.39	443.42	
Нийт дүн	815.45	1480.92	665.47	81.60%

Нийт авлагын 33.4 хувь буюу 443.42 сая төгрөг нь гэрээгээр хийсэн ажлын хөлсийг ондоо багтааж авч чадаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт №3

ДЭХ-ний авлагын үлдэгдлийг харуулбал:

Авлагын үлдэгдэл	Ангилал	2017 он	2018 он	2019 он
	ААНБ	416.0	355.3	508.2
	Айл өрх	523.7	441.4	510.3
Дүн		939.7	796.7	1,018.5

Авлагын үлдэгдэл 2018 онд өмнөх оныхоос 143.0 сая төгрөгөөр буурсан ч 2019 онд 222.8 сая төгрөгөөр буюу 27.8 хувиар өссөнийг

ДЭХ-ийн түгээлт нэмэгдсэнтэй холбоотой гэж тайлбарласан ч энэ нь компанийн үйл ажиллагаа жигд бус байгааг харуулж байна. Түүнчлэн орон сууцны зоорийн давхрын хэрэглэгчийн авлага 50,8 сая төгрөг байгаагийн 92.1 хувь нь 360 хоногоос дээш насжилттай болсон байгааг цаашид анхаарах хэрэгтэй.

Өр төлбөрийн хувьд авч үзвэл 2019 оны эцэст өмнөх оноос 670.12 сая төгрөгөөр буюу 54,8%-аар, зорилтот түвшнээс 476.29 сая төгрөгөөр буюу 33.6%-аар нэмэгдсэн байна. Үүнд дулааны төлбөрийг урьдчилж төлсөн хэрэглэгч нарын

төлбөрөөс гадна гэрээгээр гүйцэтгэсэн нэг ажлын санхүүжилт 290.5 сая төгрөгийг урьдчилж орсон орлогод дансанд бүртгэсэн нь нөлөөлжээ.

1.1.3. Ажлын дадлага туршлагатай боловсон хүчин бүрдсэн байна.

Компанийн ТУЗ байгууллагын ерөнхий бүтэц, орон тоог батлан түүнд нийцүүлэн гүйцэтгэх захирлын тушаалаар алба, хэлтэс, хэлтсийн зохион байгуулалтыг тогтоож байна. 2018 онд батлагдсан 189 орон тооноос 185, 2019 онд батлагдсан 189 орон тоогоор ажиллажээ. Үүнээс: 37 орон тоонд буюу 20.3 хувь нь инженер техникийн ажилтан байна. Нийт ажиллагсдын 86 буюу 48.3 хувь нь цаг зэргээр цалинжиж, 48.8 хувь буюу 89 ажилтан хэвийн бус нөхцөлд ажиллаж байна.

Ажиллагсдын мэргэшил, мэргэжлийн зэргийн судалгаа

Хүснэгт №4

Ажиллагсдын ангилал	Нийт	Үүнээс				
		Зөвлөх инженер	Мэргэшсэн инженер	Доктор	Магистр	Бакалавр
Удирдлага	2	1	2			2
Инженер техникийн ажилтан	36		3			33
Албан хаагч	43		1			33
Мэргэжилтэй ажилчид	108					22
Бүгд	189	1	6		0	90


Нийт ажиллагсдын дунд боловсролын доктор, магистр зэрэгтэй ажилтан байхгүй, мэргэжилтэй ажилчдаас 14 нь мэргэшлийн V, VI дугаар зэрэгтэй бол 68 нь III, II дугаар зэрэгтэй байна. Хүний нөөцийн судалгаанаас үзэхэд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт ажилтнуудын 44 хувь нь 6-15 жил, 27 хувь нь 15-аас дээш жил эрчим хүчний салбарт ажиллаж байгаа нь ажлын дадлага туршлагатай боловсон хүчнээр хангагдсан нь харагдаж байна.

Дүрслэл №1

Дүрслэл №2

Ажилласан жилийн судалгаа

Насны ангилал



Гүйцэтгэх захирлын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/18 тушаалаар томилогдон ажлын хэсэг компанийн үр ашигтай, тогтвортой ажиллагааг хангахад шаардлагатай ажиллагсдын байвал зохих орон тооны норм нормативыг тогтоох аргачлалын дагуу судалгаа хийхэд одоо байгаа 189 орон тоо 204 болж өсөхөөр

гарсан байна. Судалгааны үр дүнд хяналт удирдлагын систем нэвтэрч байгаатай холбогдуулан программ хангамжийн инженер, дулааны процессын автоматжуулалтын засварчин, сурталчилгааны мэргэжилтэн гэсэн 3 орон тоог шинээр нэмжээ.

1.2.Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

1.2.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулаагүй байна.

Дотоод хяналт мониторингийн хэлтэс нь 2016 оны 11 дүгээр сарын 01-нд байгуулагдан 2018-2019 онд бүтэц зохион байгуулалтын хувьд хэлтсийн дарга, дотоод аудитор, хяналтын инженер, эдийн засагч, ХАБЭА-н инженер, хэмнэлтийн инженер, хуулийн зөвлөх гэсэн 7 орон тооны бүтэцтэй ажиллаж иржээ. Тус хэлтэс нь 2018 оны үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гадна хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан нийт 22 удирдамжаар алба, хэлтсүүдэд дотоод хяналтыг техникийн болон санхүүгийн чиглэлээр хийхээр төлөвлөгөө гарган ажилласан байна.

Мөн Эрчим хүчний сайдын 2019 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор баталсан Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамд нийцүүлэн хяналт шалгалтын журамд өөрчлөлт оруулан мөрдөж ажиллажээ.

2019 онд “ДДС” ТӨХК-ийн бүтээмжийн ажлыг дээшлүүлэхээр чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж эрсдэл ба боломжийн үнэлгээг компанийн хэмжээнд нэгтгэн гаргажээ.

Компанийн алба, хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад 32 удирдамж батлуулан 7 хоногт 20, ажлын байрны үзлэг 2018 онд 62, 2019 онд 85 удаа хийжээ. Дотоод аудитын ажлын хүрээнд дараах чиглэлээр хяналт шалгалтыг явуулжээ.

- ❖ Санхүүгийн мэдээллийн бодит байдал
- ❖ Хөрөнгө, нөөцийн зүй зохистой ашиглалт, бүрэн бүтэн байдал /ашиглах, шамшигдуулахаас сэргийлэх/
- ❖ Худалдан авах ажиллагаа
- ❖ Хууль дүрэм, журмын хэрэгжилт

Дээрх чиглэлээр дотоод хяналт хийх талаар төлөвлөгөөнд оруулан гүйцэтгэх захирлаар батлуулан нийт 35 ажил хийхээр төлөвлөсөн ч өмнөх жилүүдийн хяналт шалгалтын дүн, илэрсэн зөрчлүүдээр мэдээллийн сан бүрдүүлээгүй, судалгаа шинжилгээнд тулгуурлан жилийн ажлын төлөвлөгөөгөө боловсруулаагүй тул анхаарч ажиллах нь зүйтэй байна.

1.2.2. Ажлын баримт материалын архивын нэгж болгох, баримтжуулах ажил хангалтгүй байна.

Аудитаар дотоод хяналт шалгалтын ажлын тайлан, баримт материал, илрүүлсэн зөрчлийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Хяналт шалгалтын ажлын баримт дутуу, нотолгоо хангалтгүй
- ❖ Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хугацаатай шаардлага өгсөн боловч хэрэгжилтийг тооцсон ч цаашдын хэрэгжилтэд хяналт тавьдаггүй
- ❖ Илэрсэн зөрчилд албан даалгавар хүргүүлэхдээ бүртгэлийн дэвтэр хөтөлдөггүй
- ❖ Илэрсэн зөрчлийг нэгтгэж мэдээллийн сан бүрдүүлж ажилладаггүй нь Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 2.7.19¹-д заасантай нийцэхгүй байна.

Дотоод хяналтаар техникийн болон санхүүгийн чиглэлээр 2018 онд 152 зөрчил илэрч 151 зөрчил бүрэн арилсан байна. Харин 2019 онд техникийн чиглэлээр 22, санхүүгийн чиглэлээр 10 удирдамж батлуулан 34 хугацаатай албан даалгавар өгч бүрэн хэрэгжүүлсэн, мөн 415 зөрчил арилгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ.

Мөн 2019 онд Бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д 7 бараа, ажил үйлчилгээний урилга, үр дүнг мэдээлээгүй, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт, их засвар, бараа материалын төлөвлөгөөг алба, хэлтсүүд гаргаж нэгтгүүлэн, үйлдвэр техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эрэмбэлж, түүнийгээ бизнес төлөвлөгөөнд нэгтгэн батлуулах ажил бодитой биш, үнэлгээний хороо байгуулах огноо, тендер зарлах огноог үндэслэлтэй, оновчтой төлөвлөөгүйгээс жил бүр төлөвлөсөн хугацаандаа хийдэггүй, тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан, үндэслэл, шууд гэрээ байгуулах аргыг сонгох болсон зэргийг нотолсон бичиг баримтыг бүрдүүлдэггүй зэрэг зөрчлүүд байна.

Өөрөөр хэлбэл дээрх зөрчлүүд нь компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж, хууль тогтоомж зөрчигдөх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт алдагдах, зориулалт бусаар зарцуулагдах, үр ашиггүй зардал гарах, хөрөнгө оруулалт, засварын ажил хугацаандаа хийгдэхгүй байх гэх мэт эрсдэлийг бий болгож байна.

“ДДС” ТӨХК нь 2019 онд ХАБЭА, ГАУС талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хяналтын чиг үүргээ зохих хэмжээнд сайн гүйцэтгэсэн байна. Тодруулбал төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, өдөр тутмын, гэнэтийн үзлэгээр илэрсэн зөрчлийг холбогдох хэлтэс, цехэд албан шаардлага өгч зарим хэрэгжилтийг нь фото зургаар баримтжуулсан байв. Дээрх ажлын үр дүнд 2019 онд осол, аваар, технологийн зөрчилгүй ажиллажээ. Гэвч ажлын баримт материалын архивын нэгж болгох, баримтжуулах зэрэг ажил хангалтгүй байна.

Иймд дотоод хяналт шалгалтын ажлын үр дүнг сайжруулах, ажлын баримт материалыг архивын нэгж болгоход удирдлагын зүгээс онцгой анхаарах шаардлагатай байна.

¹ Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, илэрсэн зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх

БҮЛЭГ 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН БИЕЛЭЛТ КОМПАНИЙН АШИГТ ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛЖЭЭ.

2.1. Компанийн ТУЗ 2018 оны борлуулалтын орлогыг 379.8 сая, 2019 онд 193.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баталсан байна.

2.1.1. Дулаан хэрэглэгчийн талбайн ашиглалтад тавих хяналт сулаас орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн тооцож, төлөвлөөгүй байна.

Компанийн үндсэн үйл ажиллагааг бодлогын баримт бичигт Дархан сумын дулаан хэрэглэгчдийг дулаанаар хангах, гэрээ байгуулах, дулааны эрчим хүчний борлуулалт хийж, орлого цуглуулах, айл өрхийн дуудлага барагдуулах, дамжуулах болон түгээх сүлжээний шугам хоолой, тоног төхөөрөмжид засвар, шинэчлэлт хийж, сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах гэж тусгажээ.

Борлуулалтын орлогыг төлөвлөхдөө өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэн худалдан авах дулааны эрчим хүчний хэрэгцээг, Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-²д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан хэрэглэгчдэд худалдах үнэ тарифаар тооцож иржээ. *Худалдах ДЭХ-ний үнэ тарифын өөрчлөлтийг хавсралт 1-ээс харна уу!*

Үндсэн үйл ажиллагааны орлогод хэрэглэгчдэд түгээсэн дулааны үнэ буюу халаалтын төлбөр, ДЭХ-ний суурь үнээс гадна халуун усны энергийн үнэ багтаж байна. ТУЗ анхны төлөвлөгөөг хянаж, тооцон үзэж, үнэ тарифын өсөлт, шинээр төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох ААНБ, хувийн орон сууц, хяналтаар нэмэгдэх талбайн хэмжээг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн судалж, 2018 оны борлуулалтын орлогыг 379.8 саяар, 2019 оныхыг 193.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баталсан байна. Борлуулалтын орлогыг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэн тооцоо судалгаа хийж төлөвлөдөг ч шинээр нэмэгдэх нийтийн орон сууц, техникийн нөхцөл худалдан авсан ААНБ, ХОС-ын гүйцэтгэл, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын дулааны талбайн ашиглалтад тавих хяналт сулаас орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн тооцдоггүй нь харагдаж байна.

2.1.2. Үйл ажиллагааны бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулж төлөвлөсөн байна.

Үйл ажиллагааны бус орлогод нийт 14 төрлийн орлого багтаж байгаа бөгөөд нийт орлогын 5.9-7.7 хувийг эзэлж байна. Орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулав.

Хүснэгт №5

Үйл ажиллагааны бус орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсан хүснэгт

Орлогын нэр	2017 он		2018 он		2019 он		Өсөлт +, бууралт -			
							2018 оны төл-с		2018 оны гүй-с	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	тоо	хувь	тоо	хувь
Үйл ажиллагааны бус орлого	180.0	508.7	427.4	508.7	362.1	737.5	-65.3	-15.3	-146.6	-28.8

Орлогыг 2018 онд төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлээс 144.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол 2019 онд 2018 оны төлөвлөлтөөс 65.3 сая, гүйцэтгэлээс 146.6 сая

² Тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх,

төгрөгөөр тус тус бууруулж төлөвлөсөн нь ДЭХ-ний алданги, хүү торгуулийн орлого, гэрээгээр гүйцэтгэх бусад ажил, үйлчилгээнээс орох орлого тодорхой бус урьдчилан төлөвлөх боломжгүйтэй холбоотой байна.

2.1.3. Үйл ажиллагааны бус орлогын 56.6-62.0 хувийг тендерийн болон гэрээгээр гүйцэтгэсэн ажлын орлого эзэлж байгаа бөгөөд энэ нь алдагдлыг бууруулахад нөлөөлж байгаа ч цаашид тендерийн ажилд анхаарлаа хэт хандуулж байгаа нь нөгөө талаас компанийн үндсэн үйл ажиллагаанд гарах эрсдэлийг тооцож үзэх хэрэгтэй юм.

2019 оны зорилтот түвшний төлөвлөгөөгөөр усаар 527.0 мян.Гкал, уураар 5.6 мян.Гкал дулааны эрчим хүч борлуулахаар төлөвлөснөөс усны төлөвлөгөө 100%, уурын төлөвлөгөө 10.8 мян.Гкал болж 193.7%-р биелэхэд “Дархан Нэхий” ХХК-ийн үйлдвэрлэлт нэмэгдэж, “Силикат” ХХК үйлдвэрлэлээ эхлүүлж уурын хэмжээгээ нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна. Борлуулалтын төлөвлөгөөнөөс 470.78 сая төгрөгөөр буюу 5.2%-аар нэмэгдэхэд эрчим хүчний борлуулалтаас гадна дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Тайлант онд 37 ААНБ, 53 хувийн орон сууц шинээр төвлөрсөн дулаан хангамжид холбогдсоноор 85.0 сая төгрөг.
- ДЭХ-ний гэрээг шинэчлэн хийхэд суурь хураамжаар 32.4 сая төгрөг.
- Гэрээний хяналт, шалгалтаар дулааны талбай нэмэгдсэнээр 19.0 сая төгрөг.
- Гэрээгүй дулаан авсан, талбайд орсон өөрчлөлтийг гэрээнд тусгуулаагүй үндэслэлээр 11 хэрэглэгчид 15.3 сая төгрөгийн нөхөн бичилт хийгдсэн.
- Үнэ тарифын өөрчлөлтөөс 190.0 сая төгрөг тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Аудитын явцад гэрээ борлуулалтын албатай хамтарсан шалгалтыг Дархан сумын зарим орон сууцны 1 давхрын үйлчилгээ явуулдаг байруудад дулааны талбайн хэмжилт, ашиглалтад шалгалт хийхэд талбайн хэмжээ зөрүүтэй, амьдрах зориулалтаар гэрээ хийсэн зарим өрөөг үйлчилгээний зориулалтаар ашигладаг, зөвшөөрөлгүй дулааны шугамд холбогдсон зэрэг зөрчил илэрсэн. Дархан сумын 13 дугаар багийн 12 дугаар байрны 01 тоотын “Ломбард”-ын айл өрхөөр гэрээ хийгдсэн 78м³ өрөөг үйлчилгээний /үсчин/ зориулалтаар, “Баян-Өргөө констракшн” ХХК мөн айл өрхөөр гэрээ хийгдсэн 71.64 м³ өрөөг барааны агуулахаар ашиглаж байв. “Жанцнууд” ХХК техникийн нөхцөл авалгүйгээр дулааны шугамд холбогдсон зөрчилд холбогдох журмын дагуу арга хэмжээ авч, дулааны талбайн хэмжээ зөрүүтэй 6 ААНБ-ын гэрээнд өөрчлөлт оруулах тухай албан шаардлага хүргүүлж, гэрээний дагуу ажиллаагүй зөрчилтэй 2 ААНБ-д талбайг эзлэхүүнээр тооцон нөхөн төлбөр тооцож 775.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Орон сууцны барилгын зориулалтыг өөрчлөн тусгайлан хаалга гаргасан, эсвэл өргөтгөл хийсэн бол хүн амьдарч байгаа эсэхийг үл харгалзан дулааны төлбөрийг эзлэхүүнээр тооцож байсныг ЭХЗХ-ны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 292 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ын 5.3.1-³

³ Аливаа барилга байгууламж орон сууц нь дулааны тоолуур суурилагаагүй бол ДЭХ-ний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзлэхүүнээр нь тооцно

дэх заалтын өөрчлөлтийн хэрэгжилттэй холбоотой зөрчил аудитаар илэрч байгааг цаашид анхаарах хэрэгтэй байна.

Үйл ажиллагааны бус орлого 2018 онд 81.3 сая, 2019 онд 375.4 сая төгрөгөөр буюу 15.3-28.8 хувиар тус тус давж биелсэн нь тухайн онуудад гэрээгээр гүйцэтгэсэн ажилтай холбоотой байна. Компанийн бизнес төлөвлөгөө жил бүр алдагдалтай төлөвлөгдөж, алдагдлаа багасгахын тулд гадны байгууллагуудад засвар, угсралтын ажил тендерээр гүйцэтгэж нэмэлт орлого олж байгаа нь нөлөөлсөн. Тухайлбал: 2019 онд “Жинсийн орой” ХХК-ийн гүйцэтгэсэн Дархан сумын 15 дугаар багийн цэцэрлэг, Шинэ Дархан дахь хуучин Спортын ордон, Гэрлэх ёслолын ордон, Дархан зочид буудал, Оюуны ирээдүй цогцолбор, Дэлхийн зөн ОУБ зэрэг байгууллагуудын гадна дулааны шугамын угсралтын ажил гүйцэтгэжээ.

ДЭХ-ээр хангах техникийн нөхцөлийг ерөнхий инженерээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс Барилгын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-⁴ д заасны дагуу ГХБХБГ-аас олгосон газрын зөвшөөрлийг үндэслэн олгож байна.

Аудитад хамрагдсан онуудад нийт 234 иргэн, ААН-д 20.9 сая төгрөгийн техникийн нөхцөл олгожээ. Техникийн нөхцөл олголтыг тулган шалгахад үндэслэх баримтгүйгээр олгосон, баримтыг нь дараа нь нөхөж бүрдүүлсэн, суурь хураамжаа төлөөгүй, хүсэлт өгсөн иргэд худалдаж авдаггүй, хүчинтэй хугацаа дууссан зэрэг зөрчил илэрсэн нь Эрчим хүчний Сайдын 2013 оны 03 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”-ын 2.5-⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд худалдагдаагүй 14 техникийн нөхцөлийн суурь хураамжийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, хүчинтэй байх хугацаа нь дууссан 3 техникийн нөхцөлийг хүчингүй болгуулахаар албан шаардлага хүргүүлээ. Техникийн нөхцөл олгож байгаа комиссын зарим хүмүүс өөрчлөгдсөн байх тул комиссын бүрэлдэхүүний шинэчлэх хэрэгтэй байна.

2.2. Үйл ажиллагааны зардал 2019 онд 217.3 сая төгрөгөөр хэтэрчээ.

2.2.1. Үйл ажиллагааны бус зардал нь гэрээт ажлууд нэмэгдэж хийсэнтэй холбоотойгоор хэтэрч байна.

ТУЗ-ийн 10 дугаар тогтоолоор “ДДС” ТӨХК-ийн 2018 онд зарцуулах нийт зардлыг 2017 оны 11 дүгээр сарын 23-ны 9,390.0 сая төгрөг байхаар төлөвлөж ТӨБЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 679 дүгээр тогтоолоор 9,338.5 сая төгрөгөөр, 2019 онд 2018 оны ТУЗ-ийн 12 сарын 19-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор 9,838.0 сая төгрөг байхаар төлөвлөж МУ-ын Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тушаалаар 9,773.9 сая төгрөг байхаар тус тус өөрчлөн баталсан байна.

⁴ Барилга, байгууламжийн техникийн нөхцөл авах хүсэлтийг энэ хуулийн 22.2-т заасан инженерийн хангамжийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ. Хүсэлтэд дараах баримт, бичгийн хавсаргана. 22.1.1 Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл.

⁵ Техникийн нөхцөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Албан бичиг, өргөдөл

2. Тодруулах хуудасны бүрдэл

3. Тухайн нутаг дэвсгэрт зориулж гаргасан Засаг даргын “Барилгын байршил тогтоож, газар ашиглуулах эрх олгох” тухай захирамж, шийдвэр

4. Мэргэжлийн комиссын хурлын шийдвэр буюу байршлын схем

5. Архитектур төлөвлөлтийн даалгавар

6. Дулааны ачаалал, хэрэглээг тогтоосон тоо хэмжээ

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл харьцуулсан судалгаа

/сая.төг/

Зардлын төрлүүд	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	Хэмнэлт +, Хэтрэлт -	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Хэмнэлт +, Хэтрэлт -
ДЭХ-ний зардал	3,031.8	3,063.7	(31.9)	3,120.3	3,193.1	(72.8)
Үйл ажиллагааны зардал	6,094.2	5,719.1	375.1	6,426.6	6,199.4	227.2
Удирдлагын зардал	119.0	116.0	3.0	118.1	118.9	(0.8)
ТУЗ-ийн зардал	41.7	40.7	1.0	51.0	61.2	(10.2)
Үйл ажиллагааны бус зардал	51.8	232.1	(180.3)	57.9	418.6	(360.7)
Нийт дүн	9,338.5	9,171.6	116.9	9,773.9	9,991.2	(217.3)

ДЭХ-ний зардлын хувьд “ДДЦС” ТӨХК-аас худалдаж авч байгаа уурын биет хэмжээ нь 2018 онд 1.9 мян.Гкал нэмэгдсэнтэй холбоотойгоор 31.9 сая, 2019 онд 5.2 мян.Гкал нэмэгдсэнтэй холбоотойгоор 72.8 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн.

Үйл ажиллагааны зардал нь 2018 онд 375.1 сая, 2019 онд 227.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд 2018 оны хувьд үндсэн хөрөнгийн элэгдэл 106.2 сая, цалингийн сан 91.3 сая, цахилгааны зардал 43.6 сая, хөдөлмөр хамгааллын зардал 11.9 сая, хүүгийн зардал 32.3 сая, нийгмийн зардал 46.9 сая төгрөг, 2019 онд үндсэн хөрөнгийн элэгдэл 230.9 сая төгрөгөөр тус тус буурсан нь гол нөлөө үзүүлжээ.

Удирдлага болон ТУЗ-ийн зардлыг 2018 онд 4 сая төгрөгөөр хэмнэсэн нь томилолтын зардал буурсан, 2019 онд 11.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн 7 дугаар тогтоолоор ТУЗ-ийн цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байв. Үйл ажиллагааны бус зардал нь гэрээт ажлууд нэмэгдэж хийсэнтэй холбоотойгоор 2018 онд 180.3 сая, 2019 онд 360.7 сая төгрөгт хэтэрчээ.

Дээрх зардлууд хэтрэхэд гол нөлөөлж байгаа шалтгаан нь уурын хэрэглээ авч байгаа байгууллагууд захиалгат хэмжээнээс нэмэгдүүлж авснаас, гэрээтээр гүйцэтгэж байгаа ажлууд төлөвлөгөөт бус ажил гүйцэтгэгдгээс хамаарч байна.

2.2.2. 2019 онд ажилтны үндсэн болон тариф цалинг 8 хувиар нэмэгдүүлжээ.

Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг 2018, 2019 онуудад удирдлага 2, захиргаа удирдлагын хэлтэс 9, санхүү бүртгэлийн хэлтэс 7, инженерийн алба 12, засварын алба 49, ашиглалтын алба 45, дотоод хяналт, мониторингийн хэлтэс 7, хангамжийн хэлтэс 20, гэрээ борлуулалтын алба 23, хэмжүүр автоматикийн алба 15 гэсэн 9 нэгж 189 ажилтантай ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан орон тоог 2018 онд Засварын алба 2, Хангамжийн хэлтэс 1, 2019 онд Засварын алба 2, Хангамжийн хэлтэс 2 тус тус дутуу ажилласан байна. /Хавсралт №2-оос харна уу/

Компанийн гүйцэтгэх захирлын 2019 оны 7 дугаар сарын 31-ны а/150 тушаалаар Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан гэрээний 3.1 дэх заалт, ТУЗ-ийн 19 дүгээр тогтоол зэргийг үндэслэн ажилтны үндсэн болон тариф цалинг 8 хувиар нэмэгдүүлжээ.

Аудитаар цалин, урамшууллыг холбогдох баримт материал, эрх зүйн актуудтай тулган шалгахад гүйцэтгэх захирлын тушаалаар шинээр ажилд орсон 23 албан хаагчдын сарын үр дүнгийн урамшуулал олгохдоо нягтлан бодогч тооцооллын алдаа гаргаж, “ДДС” ТӨХК-ийн ажилтнуудад сарын ажиллагааны үр дүнгээр шагнал олгох журмын 3.2.8-⁶ дахь заалтыг зөрчин 0.8 сая төгрөгийн урамшуулал илүү олгосон зөрчил илэрсэн. Дээрх зөрчлийг цаашид анхаарч ажиллаж давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлжээ.

Компанийн бизнес төлөвлөгөөнд 2018 оны цалингийн санг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2,951.1 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 2,844.1 сая төгрөг зарцуулж 107.0 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Энэ нь сарын бүрийн үр дүнгийн шагналт цалинг ажилчдын өвчтэй чөлөөтэй, ажлын гүйцэтгэлээс хамаарч олгосон нь хэмнэлт үүсэхэд нөлөөлжээ.

2019 онд Эрчим хүчний яамнаас 2,990.6 сая төгрөгөөр баталсан цалингийн зардлыг 11.1 сая төгрөгөөр хэтрүүлжээ. Цалингийн зардал хэтэрсэн нь ТУЗ-ийн 2019 оны 19 дүгээр тогтоол, “ДДС” ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 3.1⁷ дэх заалтыг үндэслэн ажиллагсдын үндсэн болон тариф цалинг 2019 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 8 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотойн байна. Эхний хагас жилийн байдлаар цалингийн зардал 50.3 сая төгрөгөөр хэмнэлттэй байсан учир 2019 оны төлөвлөгөөнөөс их хэмжээгээр хэтрээгүй байна. /Хавсралт №3-аас үзнэ үү/

2.2.3. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 2018, 2019 онд нийт 754.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Удирдлагын зардал:

2018 оны бизнес төлөвлөгөөнд удирдлагын зардлыг 119.0 сая төгрөгөөр төлөвлөж 116.0 сая төгрөгийг зарцуулж 3.0 сая төгрөгийг хэмнэсэн, 2019 онд 118.0 сая төгрөгөөр төлөвлөж 118.8 сая төгрөгийг зарцуулж 0.8 сая төгрөгөөр хэтэрсэн байв.

Зардал тус бүрээр авч үзвэл 2018 онд гүйцэтгэх удирдлагын албан томилолтын зардал хэмнэгдэж, 2019 онд үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 3.1 дэх заалтыг үндэслэн ажиллагсдын үндсэн болон тариф цалинг 2019 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 8 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Урсгал засвар:

2018 онд компанийн хэмжээнд хэлтэс албадын урсгал засварт гүйцэтгэлээр 311.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь төлөвлөгдсөн хөрөнгийн 87.2%-ийг

⁶ Компанид шинээр ажилд орсон ажилтанд жинхлэх хүртэл нь, албан хаагчид ажилд орсон эхний сард нь шагнал олгохгүй.
⁷ “ДДС” ТӨХК-ийн ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр нийгмийн зөвшилтийн 3 талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.6 дахин өсгөснөөс доошгүй байна. ЭХ-ний салбарын 2019-2020 оны хамтын тарифын хэлэлцээрийн 3.1 дэх заалтыг үндэслэн ажилтнуудын албан тушаалын болон тарифт цалинг 2019.06.01-ний өдрөөс 8 хувиар нэмэгдүүлнэ. Цалинг хэрэглээний үнийн индекстэй уялдуулан жил бүр нэмэгдүүлж байна.

зарцуулж 45.8 сая, 2019 онд гүйцэтгэлээр 442.3 сая хөрөнгө зарцуулсан нь төлөвлөгдсөн хөрөнгийн 95.9%-ийг зарцуулж 18.9 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна. Алба, хэлтсээс урсгал засварын зардлын төлөвлөгөөг жилээр нь төлөвлөж, сар бүрийн хийх ажлын хүрээнд хэрэгжүүлж иржээ.

Мөн алба, хэлтсийн 4, 12 дугаар сарын анхан шатны баримтууд болох хийх ажлын жилийн төлөвлөгөө, хүсэлт, шаардах хуудас, нярвын тайланг тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

Нийгмийн зардал:

Хүснэгт №7

Нийгмийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Зардлын төрөл	2018 он			2019 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Хоолны хөнгөлөлт	155.1	136.8	18.3	154.2	143.4	10.8
Унааны хөнгөлөлт	12.4	9.7	2.7	12.9	11.0	1.9
Буцалтгүй тусламж	19.0	15.9	3.1	19.8	10.7	9.1
Тэтгэмж	30.9	30.7	0.2	114.3	112.9	1.4
Эрүүл мэнд эмчилгээ	12.8	12.3	0.5	12.3	8.5	3.8
Шагнал урамшуулал	53.2	35.9	17.3	60.2	53.0	7.2
Урлаг, спорт, тэмцээн	12.9	5.8	7.1	13.3	21.4	(8.1)
Баярын арга хэмжээ	26.9	29.2	(2.3)	33.8	28.3	5.5
Түлшний хөнгөлөлт	6.0	5.9	0.1	6.0	20.1	(14.1)
Ахмадын сан	28.3	29.5	(1.2)	34.4	33.0	1.4
ДҮН	357.5	311.7	45.8	461.2	442.3	18.9

Буцалтгүй тусламжийн зардлын талаар: 2018-2019 онуудад Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.4⁸-т заасны дагуу 28 ажилтанд 26.6 сая, 5.19⁹-д заасны дагуу 1 ажилтанд 3.0 сая төгрөгийн тусламжийг тус тус үзүүлжээ.

Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн талаар: Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.8¹⁰-д” Компаниас өндөр насны тэтгэвэрт гарч байгаа ажилтнуудад салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно” гэж заасны дагуу 2018 онд 2 ажилтанд 30.7 сая, 2019 онд 7 ажилтанд 112.9 сая төгрөгийн тэтгэмжийг олгожээ.

Аудитаар Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ны 05 дугаар тогтоолоор 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320,000 төгрөг байхаар шинэчлэн

⁸ Ажиллагсдын төрсөн эцэг, эх, нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход салбарын хөдөлмөрийн доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү нь нас барж уй гашуу тохиолдоход салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний буцалтгүй тусламж үзүүлнэ.

⁹ Байгалийн гэнэтийн аюулт /гал, усны үе, газар хөдлөлт/ үзэгдэл өртөж орон гэргүй болсон, эд хөрөнгийн хохирол учирсан ажилтан хохирлын хэмжээг харгалзан нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

¹⁰ “ДДС” ТӨХК-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарахаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр бодож нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно. /тэтгэвэрт гарсан болон тэтгэвэрээ тогтоолсон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтан, ТУЗ-ийн гишүүдэд хамаарахгүй/

тогтоосон. Уг хэрэгжилтийн дагуу шалгахад тэтгэмж авсан ажилтнуудад Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.1¹¹-д заасан салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэмж олгоогүй зөрчил илэрсэн.

Аудитын явцад Эрчим хүчний салбарын 2019-2020 оны хамт /тариф/ хэлэлцээрийн 3.2¹²-дахь заалтыг үндэслэж Компанийн захиргаа, ҮЭХ-той байгуулсан хамтын гэрээ байгуулаагүйгээс болж дээрх зөрчил илэрсэн. Иймд Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрийн заалтуудыг үндэслэх зөвлөмж хүргүүлээ.

Урлаг, спорт, тэмцээний зардлын талаар: 2018, 2019 онуудад урлаг, спортын арга хэмжээний зардалд аймгийн болон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдын томилолтын зардал, унааны зардал, оролцооны мөнгө, компаниас зохион байгуулж буй тэмцээн уралдаан зэрэгт нийт 27.2 сая төгрөг зарцуулсан байна. 2019 онд баталсан төлөвлөгөөнөөс 8.1 сая төгрөг хэтэрсэн нь 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн б/2228 тоот албан бичгээр Эрчим хүчний салбарын спортын их наадам болсонтой холбоотойгоор хэтэрчээ.

Түлшний хөнгөлөлтийн талаар: Компанийн захиргаа ҮЭХ-ний хооронд байгуулсан хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.2¹³ дахь заалтыг үндэслэн гэр хороололд амьдардаг 59 ажилтан, ахмадуудад модны үнийн 50%-аар тооцож 1 хүнд 100,000 төгрөг олгожээ. Мөн бусад ажилтнуудад захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээрийг 5.2 дахь заалтыг үндэслэж 142 ажилтанд халаалтын улирлын хөнгөлөлт болон нийт 14.0 сая төгрөгийг нэмж олгосон нь түлш хөнгөлөлтийн зардал хэтрэхэд нөлөөлсөн.

2018-2019 онд нийт ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын байрны болон хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх, шагнаж урамшуулах, сургаж дадлагажуулах, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх талаар ҮЭХ-той хамтын гэрээ байгуулан гарах зардлыг бизнес төлөвлөгөөнд тусган ажилласан байна. 2018, 2019 оны жилийн эцсийн байдлаар ажилтнуудын нийгмийн зардалд нийт 754.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Дээр дурдсан хэтэрсэн зардлуудыг төлөвлөсөн хэмжээнд зарцуулсан бол 22.2 сая төгрөг хэмнэх боломж байжээ.

¹¹ “ДДС” ТӨХК-ийн ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.6 дахин өсгөснөөс доошгүй байна...

¹² Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1.6 дахин хүртэл нэмэгдүүлэн тогтоож мөрдөнө...

¹³ Ажилтнууд халаалтын улирлын хөнгөлөлтийг жилд нэг удаа 100,000 төгрөгөөр бодож олгоно. Энэхүү заалт ахмадууд болон групптэй хүмүүс, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд нэг адил хамаарна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

3.1. Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө 100 хувь биелжээ.

3.1.1. Худалдан авах бараа, ажил үйлчилгээ өмнөх онуудаас нэмэгдэж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлтэс, албадаас ирүүлсэн захиалгын үндсэн дээр хангамжийн хэлтэс нэгтгэн боловсруулж, ТУЗ-өөр батлуулжээ.

Хүснэгт №8

2018, 2019 оны бараа, ажил үйлчилгээний зардлын төсөв

/сая.төг/

№	Бараа, ажил үйлчилгээний төрөл	ТУЗ-ийн хурлаар баталсан			
		Тоо ширхэг	Төсөв /2018/	Тоо ширхэг	Төсөв /2019/
1	Их ба урсгал засвар	31	740.8	40	716.2
2	Барилгын засвар	7	191.7	7	62.9
3	Техник зохион байгуулалтын арга хэмжээ	7	139.2	16	348.0
4	Хөрөнгө оруулалт	15	255.2	13	624.2
	Дүн	60	1,326.9	76	1,751.3

“ДДС” ТӨХК 2018 онд нийт 1,326.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 нэр төрлийн, 2019 онд 1,751.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 76 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар ТУЗ-өөр баталсан байна.

3.1.2 худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Гүйцэтгэх захирлын тушаалаар худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор ажлын онцлог, хэлтэс, албадын байдлаас хамааруулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

2018 онд худалдан авах ажиллагааны 5 багц буюу 8.3 хувьд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 3 багц буюу 5 хувьд зөвлөх үйлчилгээ, 15 багц буюу 25 хувьд харьцуулалтын аргаар, 37 багц буюу 61.7 хувьд шууд худалдан авах аргаар, 2019 онд Худалдан авах ажиллагааны 5 багц буюу 6.6 хувь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 2 багц буюу 2.6 хувь зөвлөх үйлчилгээ, 20 багц буюу 26.3 хувийг харьцуулалтын аргаар, 49 багц буюу 64.5 хувийг шууд худалдан авах гэрээгээр зохион байгуулжээ.

“ДДС” ТӨХК нь тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа дараах алдаа зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- 2018 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас болох www.tender.gov.mn-д 169.449.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 тендерийг огт мэдээлээгүй, 122,780.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 тендерийн үр дүн, нийт 292,230.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 11 тендерийн үр дүнг мэдээлээгүй нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.11⁴-дэх, Сангийн сайдын тушаалаар баталсан “Цахим хуудаст худалдан авах

¹⁴ “үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх”

ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ы 7.4¹⁵-дэх заалтууд,

- 2.2018, 2019 оны Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар зохион байгуулсан 22.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Даатгалын үйлчилгээний Монгол даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Улаанбаатар даатгал ХХК гэх 3 компанид үнийн санал явуулсан. Уг 3 компаниас Улаанбаатар даатгал ХХК-аас үнийн санал ирүүлж, нөгөө 2 компаниас үнийн санал ирүүлээгүй гэж үнэлгээ хийсэн гишүүдийн хурлын тэмдэглэлд дурдсан байна. Монгол даатгал, Практикал даатгал компаниудын Дархан-Уул аймаг дахь салбартай холбогдож үнийн санал ирүүлэх тухай албан бичиг ирсэн талаар тодруулахад тус компаниас үнийн санал авах тухай албан бичиг ирээгүй болох нь тогтоогдсон. 2018 онд 19.7 сая, 2019 онд 18.4 сая, нийт 38.1 сая төгрөгийн даатгалын гэрээг хууль зөрчиж хийсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁶-дэх заалттай нийцэхгүй байна.
- 2019 онд Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан 82.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ган хаалт нийлүүлэх ажлын үнэлгээний хорооны 6 гишүүний 2 нь үнэлгээний хуудас байхгүй, үнэлгээ хийсэн баримт нь засвартай, гарын үсэг зурагдаагүй, 4 үнэлгээний хуудасны 2 нь “Дархан ар шанд” ХХК-ийг ижил төрлийн ажил гүйцэтгэсэн туршлагын баримт материал дутуу гэж тэмдэглэсэн байхад уг компанийг шалгаруулсан, 82.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ган яндан нийлүүлэх тендерийн бичиг баримтын 2 дугаар бүлгийн ТООЗ 18.2-д тендер шалгаруулалтад оролцогч компани нь сүүлийн 3 жил ашигтай ажилласан байх гэж заасан байхад 2017 онд санхүүгийн тайлангаар алдагдалтай ажилласан “Өгөөмөр баян булаг” ХХК-ийг шалгаруулсан, харьцуулалтын аргаар 32.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авах тендэрт шалгарсан “Шилмэл дизайн” ХХК-ний 2017, 2018 онуудад ижил төрлийн ажил гүйцэтгэсэн гэрээ боловч уг гэрээг дүгнэсэн акт байхгүй компани шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1¹⁷-дэх, 27.1.3¹⁸-дахь заалтуудтай тус тус нийцээгүй.

Мөн үнэлгээний хорооны гишүүдийн хурлын тэмдэглэл байхгүй, гарын үсэг дутуу зөрчлүүдэд зөвлөмж хүргүүлэв.

Бараа, ажил үйлчилгээг ижил төстэй байдлаар нь нэгтгэж нийт төсөвт өртгийн дүнгээр тендер шалгаруулалтыг зохион байгуулах боломж байсан ч нээлттэй тендер шалгаруулалтын босго үнэнд хүргэхгүйгээр төсөвт өртгийг тогтоож, харьцуулалтын аргыг сонгосон нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсвэл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.” гэж заасантай

¹⁵ “Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудаст мэдээлээгүй, буруу оруулсан тохиолдолд гэрээний төлбөр шилжүүлэхийг хориглоно”

¹⁶ “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”

¹⁷ “Энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадаахын шаардлага”

¹⁸ “Тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага”

нийцэхгүй байна. Тухайлбал: ДХТ№6 иж бүрэн автоматжуулж, ДХТ№6, 7, 8 таслах хаалтуудыг алсын удирдлагын системд шилжүүлэх ажлыг 2 хувааж “Энлает” ХХК-д 39.0 сая, 44.0 сая төгрөгөөр ажил гүйцэтгүүлсэн.

3.1.3. Худалдан авах үйл ажиллагаа 100 хувь хэрэгжсэн байна.

“ДДС” ТӨХК 2018 онд 60 багц тендерийг 1,214.4 сая төгрөгөөр хэрэгжүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй 112.5 сая, 2019 онд 76 багц тендерийн 1,655.1 сая төгрөгөөр хэрэгжүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй 96.2 сая төгрөгийг тус тус хэмнэж ажиллажээ. Тухайлбал: ДХТ№6, 7, 8-ыг автоматжуулах, компьютерын удирдлагын системд холбох, авлага бууруулахаар ажиллаж буй ажилтнуудад GPS суулгаж, борлуулалтын программтай холбох, Экскаватор 0.7м³ шанагатай, /Doosan/ Автобус /ажилчид зөөх/, гэмтэл илрүүлэх зэрэг ажлууд компанийн үйл ажиллагаанд маш хэрэгтэй ажлууд болсон байна.

3.2.1. Хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө хадгалагдаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд 4,549.6 сая, өөрийн хөрөнгөөр 1,444.8 сая, төсөл хөтөлбөрөөр 620.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлийн ажлууд хийгдсэнээр шугам сүлжээний насжилтыг уртасгаж, аюулгүй ажиллагааг ханган, хэрэглэгчдэд чанартай найдвартай ДЭХ түгээж, сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлж хөрөнгө оруулалтын үр дүн гарсан байна. Үүнээс 3,675.8 сая төгрөгийн барилга байгууламж, шугам хоолойн шинэчлэл, 707.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 403.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 16.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 89.6 сая төгрөгийн компьютер техник хэрэгсэл, 43.7 сая төгрөгийн программ хангамж нэмэгджээ.

Аудитад хамрагдсан онуудад Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 1,437.3 сая төгрөгийн нийтийн зориулалттай орон сууцны дулааны шугам хоолой, ялтсан халаагч, дулаан дамжуулах төвийг аймгийн Захирагчийн албанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, ТУЗ-ийн шийдвэрийн дагуу гүйцэтгэх захирлын тушаалыг үндэслэн бүртгэж авсан байна.

Дээрх хөрөнгүүд нь аймгийн нийтийн зориулалттай орон сууцны хороолол, шинээр баригдсан хорооллын гаднах инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгүүдийг “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу үнэ төлбөргүй хүлээн авч хөрөнгөд бүртгэсэн байна. Харин өөрийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу зохион байгуулжээ.

Аудитад хамрагдсан хугацаанд зарлага гараагүй хөрөнгийг судалж үзэхэд нийт 229 нэр төрлийн нийт 110.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө байгаагаас 70.6 сая төгрөг нь дулааны шугам сүлжээний засварт хэрэглэгдэх ган хаалтууд, мотор, редуктор зэрэг байна. Эдгээрийн ихэнх нь тухайн шугам хоолойн засвар үйлчилгээний ажилд тохирохгүй, шаардлага хангахгүй байгаа гэсэн тайлбарыг өгч байгаа тул компанийн өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлэх хэрэгтэй байна.

3.2.2. Өмч хамгаалах зөвлөл журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Компанийн захирлын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/242 дугаар тушаалаар шинэчлэн Зөвлөлийн даргаар ерөнхий инженер, нарийн бичгийн даргаар хуулийн зөвлөх, гишүүдэд ерөнхий нягтлан бодогч, дотоод аудитор, үндсэн хөрөнгийн нягтлан бодогч нарыг томилжээ. ТӨБЗГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-д нийцүүлэн тус компани өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан журам боловсруулжээ.

Өмч хамгаалах зөвлөл 2018, 2019 оны ажлын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан төлөвлөгөөний дагуу 2018 онд 3 удаа хуралдаж 3 асуудал, 2019 онд 5 удаа хуралдаж 6 асуудлыг тус тус шийдвэрлэсэн байв.

Ажлын тайлангаас үзэхэд нийтийн зориулалттай орон сууцны дулааны шугам хоолой, ялтсан халаагч, дулаан дамжуулах төвийг хүлээн авах, хуучин шугам хоолой үндсэн хөрөнгөөс хасаж, актлуулах, тухайн оны жилийн эцсийн тооллогын үр дүнг хэлэлцэж, шийдвэр гаргаснаас өөр ажил хийгээгүй байлаа. Дээрх журмын 3-т заасан өмч хамгаалах зөвлөлийн эрх, үүргийн 3.1, 3.7, 3.11, 3.13-т заасныг огт хэрэгжүүлж ажиллаагүй, хөрөнгийн ашиглалтад тавих хяналт сул байна. Өөрөөр хэлбэл: компанийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө олж авах үйл ажиллагаанд оролцоогүй, түүнд хяналт тавьж ажиллаагүй нь тус зөвлөл хангалтгүй ажилласныг харуулж байна.



Саналд өгсөн тайлбар:

д/д	Холбогдох байгууллагын санал	Тайлбар
1	<p>2.1.3. Жанцангууд ХХК Энэ зун уг дэлгүүрийг худалдаж аваад өргөтгөлд холболт хийлгэсэн. Манай гэрээний хэрэгжилтийн хяналтаар очиж шалгахад холбогдоогүй байсан. Техникийн нөхцөл зөвшөөрөлгүй дулаан авсан үндэслэлээр 2020 оны 10 дугаар сарын 20-д инженерийн албанаас үзлэг хийгээд таслах шийдвэрээр ашиглалтын алба дулааныг хааж, лацадсан. /Зургийг хавсаргасан байна./ Техникийн нөхцөл зөвшөөрөлгүй авсан үндэслэлээр 250.0 мянган төгрөгөөр торгох болохыг мэдэгдсэн.</p>	<p>Техникийн нөхцөлгүйгээр дулаанд холбосон ажлыг “ДДС” ТӨХК-аар хийлгээгүй болох нь аудитын явцад тогтоогдсон. Холболтыг хэрхэн хийлгэсэн тодорхойгүй, техникийн нөхцөл гаргуулаагүйгээр дулаан авсан нь аудитын явцад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн. Гэрээ борлуулалтын албанаас ирүүлсэн тайлбар, нотлох баримтын шаардлагыг хангахгүй байгаа тул төлбөрийн актыг хэвээр үлдээж, техникийн нөхцөлгүйгээр дулааны шугам сүлжээнд холбогдсон зөрчилд холбогдох журмын дагуу арга хэмжээ авах гэж өөрчлөв.</p>
2	<p>2.1.3.Иргэн Д.Золжаргал манай компанид техникийн нөхцөл хүссэн хүсэлт, холбогдох материал бүрдүүлж өгсөн боловч бусад хэрэглэгчээс холбуулах зөвшөөрөл аваагүй учраас техникийн нөхцөл гараагүй болно.</p>	<p>Техникийн нөхцөл олгосон гэж хүсэлтийг шийдвэрлэсэн байх тул хэвээр үлдээсэн.</p>
3	<p>3.2.2. Өмч хамгаалах зөвлөлийн 2018, 2019 оны ажлын төлөвлөгөөг журамд заасан хугацаанд тухай бүр гүйцэтгэх захирлаар батлуулж ажилласан. /2018, 2019</p>	<p>Өмч хамгаалах зөвлөл 2018, 2019 оны ажлын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан төлөвлөгөөний дагуу 2018 онд 3 удаа хуралдаж 3 асуудал, 2019 онд 5 удаа хуралдаж 6 асуудал шийдвэрлэсэн байв гэж өөрчлөв.</p>

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- “ДДС” ТӨХК үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулаагүй байна.
- Компанийн зорилтот түвшинг 2018 онд 100 хувь, 2019 онд 98.6 хувиар биелүүлж, батлагдсан алдагдлыг бууруулж ажиллажээ.
- Компанийн хүний нөөц ажлын дадлага туршлагатай боловсон хүчнээр бүрдсэн байна.
- Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.
- Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулаагүй байна.
- Хяналт шалгалтын ажлын баримт материалыг архивын нэгж болгох, баримтжуулах ажил хангалтгүй байна.
- Үйл ажиллагааны бус зардал нь гэрээт ажлууд нэмэгдэж хийсэнтэй холбоотойгоор хэтэрч байна.
- Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 2019 онд 442.3 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 29.5 хувиар өссөн байна.
- Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг 100 хувь биелүүлж, ажилласан байна.
- Худалдан авах бараа, ажил үйлчилгээ өмнөх онуудаас нэмэгдсэн байна.
- Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.
- Хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгө хадгалагдаж байна.
- Өмч хамгаалах зөвлөл журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

“ДДС” ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга Т.Батдондог-т:

- Компанийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажилд хяналт тавих;

“ДДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Гантуул-д

1. Компанийн үйл ажиллагаа, үр өгөөжийг сайжруулах, алдагдлыг бууруулж, ашигтай ажиллахад анхаарах;
2. Борлуулалтын орлогыг шинээр нэмэгдэх нийтийн орон сууц, техникийн нөхцөл худалдан авсан ААНБ, ХОС-ын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтийн хяналт шалгалтын орлогыг үндэслэн бодитой төлөвлөж байх;
3. Үйл ажиллагааны бус орлого буюу тендерийн ажилд анхаарлаа хэт хандуулж байгаад дүгнэлт хийж, компанийн үндсэн үйл ажиллагаанд гарах эрсдэлийг тооцож байх;
4. Орон сууцны нэг давхрын үйлчилгээ явуулдаг иргэд, ААНБ-ын байруудад дулааны талбайн хэмжилтэд хяналт шалгалт хийж, гэрээг шинэлэх ажил зохион байгуулах;
5. Дотоод хяналт, шалгалтын үр нөлөөг сайжруулж, илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулж, ажлын баримт материалыг архивын нэгж болгох;
6. Техникийн нөхцөл олгож байгаа комиссын бүрэлдэхүүнийг шинэчилж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
7. Нийгмийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах, ялангуяа спортын тэмцээн уралдаан, баяр ёслол зэрэг арга хэмжээнд олгож байгаа зардлыг цаашид бууруулах;
8. Худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийг мөрдөж ажиллах;
9. Хөрөнгийн зах зээлийн үнэ ханшийн судалгаанд үндэслэн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлж, худалдан авах төлөвлөгөөнд тусгаж байх;
10. Агуулахад бүртгэлтэй байгаа хөрөнгүүдийн хэрэгцээг судалж, цаашид инженерийн шугам, хоолойн засварт хэрэглэх талаар арга хэмжээ авч ажиллах;
11. Компанийн өмч хамгаалах зөвлөлийг журмын дагуу ажиллуулахад хяналт тавьж, жилийн ажлын тайланг хэлэлцэж, үр дүнг тооцож байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 10-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2020.10.30

ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1

Шинээр мөрдөж эхэлсэн үнэ тарифын судалгаа

Мөрдсөн он		2015 он		2016 он	2017 он	2018 он	2019-2020 он	
ЭХЗХ-ны тогтоолын дугаар, огноо		2014-11-19 №195	2015-07-06 №205	өөрчлөлт ороогүй	2017-09-07 №225	2018/10/25 №314	2019-03-25 №120	
Мөрдөж эхэлсэн огноо		1/1/2015	7/25/2015		10/1/2017	11/15/2018	6/1/2019	
Үйлдвэр ААНБ-н хэрэглэгчдэд борлуулах дулааны үнэ								
Ангилал		Хэмжих нэгж						
Үйлдвэр ААНБ-н халаалт	төг/м3	373	429		429	470	470	
	төг/Гкал	20,318	23,366		23366	26871	26871	
	төг/Гдж	4,854	5,582		5582	6419	6419	
Технологийн халуун ус	төг/Гкал	11,237	12,923		12923	12923	14210	
	төг/Гдж	2,683	3,085		3085	3085	3394	
Албан байгууллагын ХХУс халаасан дулаан	төг/хүн	3,846	4,423		4423	4423	4865	
	төг/тн							
	төг/м3	1,279	1,599		1599	1599	1759	
	төг/Гкал	8,382	9,639		9639	9639	10605	
	төг/Гдж	2,003	2,303		2303	2303	2533	
Уур 8-13 ата	Жилийн хэрэглээ 1000Гкал хүртэл	төг/Гкал	23,052	26,510		23064	23064	25377
		төг/Гдж	5,506	6,332		5510	5510	6061
	Жилийн хэрэглээ 1000Гкал-аас дээш	төг/Гкал				20400	20400	22440
		төг/Гдж				4873	4873	5360
Уур 20 ата	төг/Гкал	28,239	32,475		25000	2500	27500	
	төг/Гдж	6,745	7,757		5972	5972	6569	

Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны үнэ									
Ангилал			Хэмжих нэгж						
Орон сууцны халаалт / оюутны байр, 00-н өрөө, подваль /			төг/м2	400	460		460	460	506
			төг/Гкал	9,085	11,356		11356	11356	14323
			төг/Гдж	2,170	2,713		2713	2713	3421
Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	хүний тоогоор	нээлттэй	төг/хүн	1,476	1,700		1700	1700	1870
		хаалттай	төг/хүн	2,218	2,551		2551	2551	2806
	Усны зарцуулалтаар		төг/м3					2273	2500
	Хэмжүүрээр тооцох		төг/Гкал					14325	15760
			төг/Гдж					3422	3764
Ахуйн хэрэглэгчдийн ДЭХ-ний үйлчилгээний тариф									
40 м2 хүртэл талбайтай айл өрх			төг/сар	3,000	3,000		3000	3000	3300
41 м2-аас 80м2 хүртэл талбайтай айл өрх			төг/сар	5,000	5,000		5000	5000	5500
81 м2-аас дээш талбайтай айл өрх			төг/сар	10,000	10,000		10000	10000	11000



Хавсралт №2

2018-2019 оны “ДДС” ТӨХК-ийн орон тооны харьцуулсан судалгаа

Хэлтэс, албадын нэр	2018 он			2019 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Удирдлага	2	2		2	2	
Захиргаа удирдлагын хэлтэс	9	9		9	9	
Дотоод хяналт мониторингийн хэлтэс	7	7		7	7	
Санхүү бүртгэлийн хэлтэс	7	7		7	7	
Инженерийн алба	12	12		12	12	
Засварын алба	49	47	2	49	47	2
Ашиглалтын алба	45	45		45	45	
Хэмжүүр автоматикийн алба	15	15		15	15	
Гэрээ борлуулалтын алба	23	23		23	23	
Хангамжийн хэлтэс	20	19	1	20	18	2
Нийт дүн	189	186	3	189	185	4

Хавсралт №3

Цалингийн зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулсан судалгаа

/сая.төг/

Хэлтэс, албадын нэр	2018 он			2019 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Захиргаа удирдлагын хэлтэс	144.5	141.2	3.2	145.0	147.8	(2.8)
Дотоод хяналт мониторингийн хэлтэс	142.7	134.6	8.0	146.3	148.5	(2.2)
Санхүү бүртгэлийн хэлтэс	130.2	140.1	(9.9)	136.8	144.3	(7.5)
Инженерийн алба	252.4	264.8	(12.4)	262.7	269.8	(7.1)
Засварын алба	702.8	636.9	65.9	708.6	698.8	9.8
Ашиглалтын алба	709.5	691.5	18.0	700.1	711.2	(11.1)
Хэмжүүр автоматикийн алба	232.6	204.3	28.4	235.5	246.4	(10.9)
Гэрээ борлуулалтын алба	352.5	337.7	14.8	366.2	358.5	7.7
Хангамжийн хэлтэс	284.0	293.0	(9.0)	289.5	276.5	13.0
Нийт дүн	2,951.1	2,844.1	107.0	2,990.6	3,001.7	(11.1)